

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	31
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	БОДЬ ДААТГАЛ ХК					
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	ОЛОН УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ					
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал					
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар	
		Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай		2021.03.31		ТУЗ/2107	
6	Цахимаар борлуулах эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм <input type="checkbox"/> Үгүй					
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр			
		Балсан		Баярмагнай			
Мэдээллийн төрлийг сонгоно уу.							
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх						
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл							
9	Даатгалын зүйл	Даатгуулагч, даатгагдагчийн эрүүл мэнд					
	Даатгалын үндсэн эрсдэл	Даатгуулагчийн эрүүл мэндэд учирсан эмнэлэг, эмчилгээний зардал					
	Даатгалын нэмэлт эрсдэл	-					
	Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	Тухайн даатгуулагчийн насны ангилал болон сонгосон багцын хамгаалалтын хязгаараас хамаарна.					

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ

Дараах үзлэг шинжилгээ, эмчилгээ үйлчилгээ түүнтэй холбогдох аливаа нөхцөл, үйл ажиллагаа болон тэдгээртэй холбоотой эсвэл тэдгээрийн үр дагаврын зардал нь энэхүү даатгалын гэрээний хасалт хэсэгт хамрагдах бөгөөд бид дараах зүйлийг хариуцахгүй болно. Үүнд:

1. Даатгагч болон даатгагдагчид урьдчилан бичгээр тохиролцсон байхаас бусад тохиолдолд хамгаалалтын хүснэгтэнд багтаагүй аливаа мэс засал,
2. Төрөлхийн эмгэгтэй холбоотой зардал болон уг өвчний эмчилгээний аливаа зардал;
3. Даатгагдагчийн хамгаалалтын хүснэгтэнд зааснаас бусад тохиолдолд болон хамгаалалтын хязгаараас давсан жирэмслэлт ба төрөлтийн аливаа зардал;
4. Эмнэлгийн аргаар үр тогтоон жирэмсэлж хүүхдээ төрүүлснээс хойш эхний ер (90) хоногт эхлүүлсэн эсвэл цаашид хийх шаардлагатай эмчилгээ;
5. Даатгагдагч тээгч эх эсвэл өөр эмэгтэй хүнээр хүүхдээ тээлгэж буй эхийн аль нь байхаас үл хамааран тухайн жирэмслэлттэй шууд холбоотой эмчилгээ;

6. Ургийн мэс ажилбар. Үүнд эхийн хэвлийд байх хугацаанд нь ургийг эмчлэхийг хамруулж ойлгоно.
7. “Төрөхийн өмнөх болон дараах хүндрэлүүд”-ийн хамгаалалтанд багтсан байхаас бусад тохиолдолд жирэмслэлтийг таслан зогсоох ба үүнээс үүдэн гарах үр дагаврууд;
8. Жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх, үргүйдлийн шинжилгээ ба эмчилгээ, үр тогтоох чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн эмчилгээ (тэр дундаа цаашдын үр зулбалтаас урьдчилан сэргийлэх эмчилгээ), үр зулбалтын шалтгааныг судлах, эмнэлгийн аргаар үр тогтоох аргыг судлах, үргүй болгох (эсвэл эсрэг эмчилгээ) ажилбар эсвэл тэдгээр ажилбарын үр дагавар буюу тэдгээртэй холбоотой аливаа эмчилгээ;
9. Бэлгийн сулрал эсвэл түүний аливаа үр дагаврын эмчилгээ;
10. Бэлгийн ажиллагааны алдагдал эсвэл түүний аливаа үр дагаврын эмчилгээ;
11. Бэлгийн замаар халдварладаг өвчний эмчилгээ;
12. Хүйс солих мэс засал эсвэл мэс заслын эсвэл эмийн эмчилгээ, тэр дундаа хүйс солиулах үйл явцаас үүдэн бий болсон эсвэл түүнтэй шууд болон шууд бус холбоотой сэтгэл засах үйлчилгээ эсвэл бусад ижил төстэй үйлчилгээ;
13. Хүний дархлал хомсдолын вирусын (ХДХВ) халдвар болон Дархлалын олдмол хомсдолын (ДОХ) хам шинжийн улмаас бий болсон аливаа эрүүл мэндийн байдлын эмчилгээ даатгагдагчийн хамгаалалтын хүснэгтэнд зөвшөөрөгдсөн байхаас бусад тохиолдолд);
14. Хэт таргалалт (биеийн жингийн индекс/ВМІ нь 35 ба түүнээс дээш) эсвэл түүнээс үүдэлтэй эсвэл ямарваа нэгэн байдлаар холбоотой аливаа эрүүл мэндийн байдлын эмчилгээ;
15. Илүүдэл жингийн мэс заслын зардал (мэс засал хийлгэх шаардлагатай болсон шалтгаанаас үл хамаарна). Үүнд ходоод боох эсвэл тайрах мэс засал багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
16. Биеийн аль нэг хэсгээс өөх эсвэл илүүдэл эд эсийг салгаж авах (хөх багасгах мэс засал гэх мэт үүгээр хязгаарлагдахгүй). Энэ нь эрүүл мэндийн эсвэл сэтгэл зүйн шаардлага бий эсэхээс үл хамаарна.
17. Даатгалын гэрээний нөхцөлийн дагуу эд эрхтэн шилжүүлэн суулгахыг зөвшөөрсөн байсан ч донор эрхтэн эсвэл эд эс цуглуулах эсвэл бусад холбогдох зардал (үүнд донор хайж олох зардал багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй).
18. Өөрийн бие эрхтэнд санаатайгаар учруулсан гэмтэл эсвэл амиа хорлох оролдлогын шууд болон шууд бус үр дагаврыг арилгах эмчилгээ;
19. Хүүхэд өсгөх болон бусад төрлийн сургалтууд (үүнд эцэг эх болоход бэлтгэх сургалтууд багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй) бүх төрлийн сургалт/курс/хөтөлбөр (үүнд архи, тамхи, хар тамхи эсвэл мансууруулах бодисын хэрэглээг зогсоох хичээлүүд багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй).
20. Никотин эсвэл тамхины хамаарлын эмчилгээтэй холбоотой аливаа зардал (үүнд никотин орлуулах эмчилгээ багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй) эсвэл архи, болон бусад төрлийн бодисын буруу хэрэглээ, тун хэтрүүлэх зэрэгтэй холбоотой эсвэл энэхүү хэрэглээнээс үүдэлтэй эмчилгээ;
21. Хол ба ойрын харааны согог эсвэл харалган гэх мэт нүдний гажиг засах эмчилгээ (даатгагдагчийн хамгаалалтын хүснэгтэнд зөвшөөрөгдсөн байхаас бусад тохиолдолд) нүдний лазер хагалгаа;
22. Суралцах бэрхшээл, зан байдлын бэрхшээл, бие бялдрын болон сэтгэцийн бэрхшээлтэй холбоотой аливаа үзлэг, эмчилгээний төлбөр. Үүнд үсэг таньж унших бэрхшээл (dyslexia), хөдөлгөөний бэрхшээл (dyspraxia), нийгмээс тусгаарлагдах эмгэг (autistic spectrum disorder), анхаарлын дутагдал, хэт хөдөлгөөний эмгэг (attention deficit hyperactivity disorder (ADHD)) болон хэл ярианы бэрхшээл багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
23. Урьдчилан сэргийлэх эмчилгээ (гэрээгээр төлөгдөх зайлшгүй хийгдэх эмчилгээтэй хамааралгүй төлбөр болон түүнтэй холбоотой нэмэгдүүлэн тооцсон зардал);
24. Даатгагдагчийн хамгаалалтын хүснэгтэнд заагаагүй эмчилгээний үр дүнд учирсан зардал, тэр дундаа эмчилгээний нэмэлт өртөг;
25. Нэг хоногийн өрөөний төлбөр (“Basic” болон “Standard” багцад хамааралтай)-ийн хүснэгтэнд заасан хязгаараас давсан, энгийн тусдаа өрөөнд эсвэл тасагт хэвтэн эмчлүүлэх эсвэл илүү өндөр зэрэглэлтэй өрөөнд шилжин хэвтэх, тансаг цэсээс захиалга хийх, үйлчлүүлэгчдэд зориулсан энгийн хоолны төрөлд багтаагүй цэсээс хоолны захиалга хийсэнтэй холбоотой эмнэлгийн нэмэлт төлбөр;
26. Өвчлөл, гэмтэл бэртлийн улмаас биш харин хөгшрөлт, цэвэршилт, бэлгийн бойжилт гэх мэт физиологийн болон байгалийн жамаар бие эрхтэнд өөрчлөлт орохтой холбоотой нийтлэг шинж тэмдгүүдийг хөнгөвчлөх эмчилгээ;
27. Даатгагдагч нь цалин эсвэл мөнгөн урамшуулал, тэр дундаа тэтгэлэг авч оролцдог аливаа спортын тэмцээний бэлтгэл сургуулилт хийсэн эсвэл түүнд оролцсоны улмаас хийх шаардлагатай болсон эмчилгээ үйлчилгээ;
28. Өндрөөс үсрэх, хадан цохионоос үсрэх, зөвшөөрөлгүй хөлөг онгоц жолоодох, суралцаж байх үедээ хөлөг онгоц жолоодох, зодооны урлаг, чөлөөт авиралт, олстой эсвэл олсгүйгээр ууланд авирах, усанд 10 метрээс доош гүнд шумбах, 2,500 метрээс дээш өндөрт явган аялах, гүүрнээс олсон бэхэлгээтэй үсрэх, каное завиар уралдах, дельтапланаар нисэх, паракланаар эсвэл микролайтинггаар нисэх, шүхрээр буух, агуй судлах, цанаар цанын зам дээр гулсах эсвэл ийм зам дээр явагддаг аливаа өвлийн спортод оролцох зэргээс учирсан гэмтэл бэртлийн эмчилгээ;

29. Даатгагдагчийн сонгосон багцын дагуу тусгайлан хасалт хийсэн эмчилгээ, тэр дундаа даатгагдагчид зориулагдсан гэрээний хавсралт эсвэл нэмэлт нөхцөлд заасан эрүүл мэндийн байдал, даатгагдагчийн багцын хүснэгтэнд багтаагүй аливаа эрүүл мэндийн зардал;
30. Даатгалын хураамж төлбөрийн хуваарийн дагуу төлөгдөөгүй байх хугацаанд хийгдсэн аливаа эмчилгээний төлбөр;
31. Рашаан сувилалын газар, байгалиар буюу спа аргаар эмчлэх эмнэлэг, бие бялдаржуулах төв эсвэл эдгээртэй ижил төстэй байгууллагаас ногдуулсан төлбөр (уг байгууллага нь албан ёсны эмнэлгийн багцтай эсэхийг үл харгалзан);
32. Даатгалын гэрээнд заасан хам-төлбөр, өөрийн хүлээх хариуцлагад хамаарах дүн;
33. Эмч, эмнэлэг, лаборатори эсвэл эмнэлгийн үйлчилгээний аливаа зохих үндэслэлгүй буюу нийтлэг бус төлбөр тооцоо;
34. Эмнэлгийн хангамж, үйлчилгээний хангалт эсвэл гүйцэтгэлтэй холбоотой аливаа төрлийн захиргааны зардал, тайлан эсвэл эмчилгээний бус шинж чанартай төлбөр тооцоо;
35. Банк болон зээлийн үйлчилгээний хураамж;
36. Даатгагдагчид хийж буй эмчилгээтэй холбоогүй эмчийн үзүүлсэн эмчилгээ болон эмийн өртөг;
37. Энгийн нөхцөлд худалдан авах боломжтой нэмэлт бүтээгдэхүүний нэхэмжлэл: Үүнд витамин, эрдэс, органик бодисууд багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
38. Эмчилгээний хүрээнд зөвлөсөн эсвэл эмчилгээний нөлөө үзүүлдэг гэдгийг хүлээн зөвшөөрсөн байсан ч хамаагүй шим тэжээлийн бэлдмэлүүд: Үүнд нярай хүүхдийн найруулдаг сүү болон гоо сайхны бүтээгдэхүүн багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
39. Даатгагдагчийн багцын хүснэгтийн хүрээнд зөвшөөрөгдсөн байхаас бусад тохиолдлын сэтгэцийн эмчилгээ;
40. Өөрийн биеэс авсан эсвэл донорын өгсөн эд эрхтний хөлдөөн хадгалалт, амьд эд эсийн суулгац эсвэл дахин суулгац;
41. Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагагүй гэж үздэг эмчилгээ эсвэл зөвхөн өөрийн сонголтоор хийлгэдэг эмчилгээ;
42. Амбулаторийн эмчлэх боломжтой гэж үздэг өвчнийг хэвтэн эмчлүүлэх эмчилгээ;
43. Генетикийн шинжилгээ эсвэл уг шинжилгээний дараа заавал авах шаардлагатай зөвлөгөө (тухайн шинжилгээ нь даатгагдагч генетикийн хувьд ирээдүйд аливаа нэг эрүүл мэндийн асуудал гарах магадлалтай гэдгийг тогтоох зорилготой байсан ч хамаагүй). Энэ төрлийн шинжилгээ нь аливаа нэг эрүүл мэндийн асуудал магадлалтай эсэхийг тогтоох зорилготойгоос биш тухайн эрүүл мэндийн байдлыг анагаахад зориулагдаагүй байдаг.
44. Ердийн ариун цэврийн хэрэглэл, үүнд шампунь, саван, шүдний оо, ам зайлагч, нүүр цэвэрлэгч шингэн, чийгшүүлэгч, ариутгагч, шүршүүрийн шингэн саван, жирэмслэлтээс хамгаалах эм, толгойн өвчин болон ханиадны эм (жороор эсвэл жоргүй олгогддог) багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй. Мөн даатгагчийн утасны төлбөрийг төлөхгүй.
45. Бүх төрлийн нойрны эмгэг, тэр дундаа хурхирах, нойргүйдэлт, унтахад саад болдог амьсгал тасалдалт, нойрны байдлыг судлах туршилтууд багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй.
46. Үс уналтын шалтгааныг тодорхойлох үзлэг эмчилгээ;
47. Бүх төрлийн багта, түүнтэй холбоотой эмчилгээ;
48. Чих эсвэл биеийн аль нэг хэсгийг цоолуулах, шивүүлэх эсвэл эдгээрийн улмаас хийх шаардлагатай болсон эмчилгээ;
49. Мэдрэлийн системийн байнгын гэмтлийн улмаас эсвэл даатгагдагч тасралтгүй ухаангүй байдалд (persistent vegetative state) орсны улмаас эмнэлэгт ерэн (90) хоногоос дээш хугацаагаар хэвтэх шаардлагатай эмчилгээ . Даатгагчийн зүгээс тасралтгүй ухаангүй байдал гэдэгт аливаа мэдрэмжээ алдсан, бүрэн ухаан алдсан байдлыг (тухайн хүн нь нүдээ нээж, амьсгалын аппаратгүйгээр амьсгалах чадвартай байсан ч хамаагүй), мөн тухайн хүн нэрийг нь дуудах эсвэл биед нь хүрэхэд ямар нэг байдлаар хариу мэдэгдэхгүй байхыг хэлнэ. Уг байдал нь дөрөв буюу түүнээс дээш долоо хоног ямар нэг байдлаар сайжралгүй үргэлжилсэн бөгөөд эмчлэх ямар ч боломжгүй байх ёстой.
50. Эмчилгээ хийлгэх үед Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ), Америкийн Нэгдсэн Улс (АНУ) ба/эсвэл Европын Холбоо (ЕХ)-ны хоригт багтах улс оронд хийгдсэн эмчилгээ эсвэл үйлчилгээний өртөг зардал;
51. Дараах шинжилгээ, үзлэг эмчилгээ, зүйл нөхцөл , үйл ажиллагаа болон тэдгээртэй холбоотой эсвэл тэдгээрийн үр дагаврын зардлыг энэхүү гэрээнд хамаарахгүй хасагдсан бөгөөд дараах зүйлийг хариуцахгүй болно. Үүнд:
 - 51.1 Косметик (гоо сайхны) хагалгаа эсвэл эмчилгээ.
 - 51.2 Урьд өмнө нь хийгдсэн косметик эмчилгээ/нөхөн сэргээх хагалгаатай холбоотой эмчилгээ, эсвэл түүний улмаас хийх шаардлагатай болсон аливаа эмчилгээ.
 - 51.3 Үр дүнтэй болох нь тогтоогдоогүй эсвэл сорилтын буюу клиник туршилтын үе шатанд байгаа эмийн хэрэглээ. Өөрөөр хэлбэл хэрэв даатгагдагч тухайн эмчилгээг европт хийлгэж байгаа бол тухайн эм нь Европын Эмийн Агентлаг (European Medicines Agency)-аас зөвшөөрөгдсөн

байх ёстой. Эсвэл дэлхийн өөр улс оронд хийлгэж байгаа бол АНУ-ын Хүнс, эмийн удирдах байгууллага (US Food and Drug Administration (FDA))-аас зөвшөөрөгдсөн байх ёстой бөгөөд тухайн лицензийн нөхцөлийн хүрээнд ашиглагдах ёстой.

51.4 Үр дүнтэй болох нь тогтоогдоогүй эсвэл туршилтын үе шатанд байгаа эмчилгээ. Үр дүнтэй болох нь тогтоогдсон эмчилгээ гэдэг нь аюулгүй, үр дүнтэй бөгөөд нотлогдсон эмчилгээ болохыг нь нийтэд хүлээн зөвшөөрүүлэх зорилгоор клиник туршилт болон үнэлгээ хийсэн, эрүүл мэндийн нэр хүнд бүхий сонин сэтгүүлд хангалттай хэмжээнд нийтлэн гаргаж нотолсон процедур, практик туршлагыг хэлнэ.

51.5 Хэрэв цөмийн хаягдал, биологи, химийн бохирдлын улмаас үүссэн, дайн байлдаантай холбогдолтой, дайнд оролцогч тал болсон(батлагдсан/батлагдаагүй), гаднын хүчин зүйлийн нөлөөлөл, хууль бус гэмт хэргийн шинжтэй үйл хэрэг, халдлага, иргэний дайн, үймээн самуун, бослого, хувьсгал, дайны зэвсгийн тэсрэлт эсвэл дээрх жагсаалт дахь хэргүүдтэй төстэй үйл ажиллагааны үед даатгагч тал эмнэлгийн үйлчилгээний төлбөрийг хариуцахгүй ба олон улсын яаралтай түргэн тусламжийг үзүүлэхгүй болно. Даатгалын тохиолдолд даатгагдагч өөрийн болгоомжгүй үйлдлээс болон аюул осолд өртсөн байдлыг (үүнд аюултай газар уруу явах гэх мэт) багтаана.

Тодруулга: Цөмийн, биологийн, химийн хаягдлын шалтгаантай холбогдолгүй алан хядах үйл ажиллагааны уршгаар үүдэн гарах эмчилгээг даатгагч тал хариуцна.

52. Эмчилгээ хийлгэснээс хойш зургаан (6) сарын дотор даатгагч нөхөн төлбөрийн нэхэмжлэхийг хүлээн аваагүй тохиолдолд нөхөн төлбөр олгохгүй.